

“Улаанбаатар БҮК”ХК-ийн ТҮЗ-ийн 2018 оны ...
дугаар сарын 07.-ний өдрийн ... дугаар тогтоолын хавсралт
2018/15

**“УЛААНБААТАР БҮК”ХК-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД АУДИТ ХИЙХ
ХАРААТ БУС АУДИТЫН КОМПАНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ,**

АЖЛЫН ЧАНАРЫГ ХЯНАХ ЖУРАМ

Нэг. Журмын зорилго, хамрах хүрээ

1.1 “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТҮЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4-д заасны дагуу Компанийн санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын компанийг сонгон шалгаруулах, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Хараат бус аудитын компанийг сонгон шалгаруулахтай холбогдуулан олон нийтэд нээлттэй зар өгөх, сонгон шалгаруулалтанд оролцох санал хүсэлтээ ирүүлсэн аудитын компаниудын баримт материалыг хүлээн авч бүртгэх, судалгаа гаргах, ирүүлсэн баримтын бүрдэл, тэдгээрт тавигдах шаардлагад нийцүүлэн хураангуй бүртгэлд оруулах, аудитын компаниудад мэдээлэл өгөх зэрэг үйл ажиллагаанд Аудитын хорооны дарга гишүүд ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга оролцоно. Тодорхой асуудлаар нэмэлт мэдээлэл шаардлагатай тохиолдолд Компанийн СҮГ-ын дарга, Ерөнхий нягтлан бодогч сонгон шалгаруулалттай холбоотой үйл ажиллагаанд оролцож саналаа илэрхийлж болно.

1.3. Аудитын байгууллагын сонгон шалгаруулалтын дүнг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор багтаан гаргах ба гарах зардлыг дараа жилийн төсөвт суулгана.

Хоёр. Хараат бус аудитын Компанийг сонгох

2.1 Сонгон шалгаруулалтыг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан явуулна.

2.2 Гүйцэтгэгчээр Санхүүгийн Зохицуулах хорооноос аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон хараат бус аудитын компанийг сонгоно.

2.3.Хөндлөнгийн аудитын Компаниудын гүйцэтгэсэн ажлын тайлан судалгааг харьцуулах зорилгоор 5 жилд 1 удаа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн томоохон топ Аудитын компаниар тухайн жилийн санхүүгийн тайланд аудит хийлгэхээр шийдвэрлэж болно.

2.4 Аудитын Компанийг сонгон шалгаруулахтай холбогдуулан Аудитын хороо дараах ажил үүргийг гүйцэтгэнэ.

-Хараат бус аудитын компани сонгон шалгаруулах тухай зар мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлах, СЗХ-д бүртгэлтэй тусгай зөвшөөрөл бүхий компаниудын хаягаар урилга хүргүүлэх

-Аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий хараат бус аудитын компаниудын жагсаалтыг гаргах.

-Хараат бус аудитын компаниудын өмнөх хугацааны санхүүгийн тайлангийн аудитын ажлын чанарын судалгаа гарах

-Сонгон шалгаруулалтын баримт бичиг боловсруулах, сонгон шалгаруулалтанд оролцох урилгыг зарлан мэдээлэх, баримт хүлээж авах,

-Санал ирүүлэх хугацааг зарыг мэдээлсэнээс хойш ажлын 7-оос доошгүй өдрөөр тогтоож, дэлгэрэнгүй жагсаалтад урилгын хариуд санал ирүүлсэн хараат бус аудитын компанийг оруулах,

-Захиалагчаас хүссэн хариу тодруулга, нэмэлт мэдээллийг бүх сонирхогчдод нэгэн зэрэг бичгээр өгөх.

2.5. Аудитын хороо нь дэлгэрэнгүй жагсаалтад багтсан этгээдээс дараах шаардлагыг хангасан этгээдийг хураангуй жагсаалтад бүртгэнэ. Үүнд:

- Улсын бүртгэлийн гэрчилгээ, аудит хийх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь тухайн жилд аудит хийх хуулийн цаглабар хугацаатай нийцсэн эсэх

- Аудитын компанийн захирал нь мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй эсэх;

- Аудитын компани нь 3-аас доошгүй мэргэшсэн нягтлан бодогчтой эсэх;

- Аудитын компанийн захирал болон мэргэшсэн нягтлан бодогчид нь мэргэжлийн ёс зүйн алдаа гаргаагүй талаар Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт (ММНБИ)- ийн тодорхойлолттой эсэх;

- ХК-ийн захиалгаар сүүлийн 3 жилийн хугацаанд аудитын ажил гүйцэтгэж байсан туршлагатай байх;

2.6.Хураангуй жагсаалтад хамгийн өндөр оноотой үнэлэгдсэн 1 аудитын компанийг Аудитын хороо сонгож шийдвэрээ ТУЗ-ийн хуралд оруулж хэлэлцүүлнэ.

Хураангуй жагсаалтад бүртгэгдсэн аудитын компаниудын саналд оноо өгөхдөө дараах үзүүлэлтийг харгалzan үзнэ.

№	Үзүүлэлт	Оноо
1	Оролцогчийн санал болгож буй аудитын ажлын хөтөлбөр болон аргачлал	25 оноо
2	Аудитын ажлыг гүйцэтгэж байсан тусгайлсан туршлага	25 оноо
3	Мэргэжилтнүүдийн чадвар болон туршлага	25 оноо
4	Аудитын үйлчилгээний үнэ	25 оноо
	нийт	100 оноо

2.7. Сонгогдсон аудитын компанийтай Гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмжийг Компанийн Гүйцэтгэх захиралд өгөх ба “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ”-ний загварыг /нэгдүгээр хавсралт/ Аудитын хороо батална.

2.8. Аудитын хороо Нарийн бичгийн даргаар дамжуулан сонгон шалгаруулалтын хаваст хэрэг бүрдүүлж архивт шилжүүлнэ.

2.9. Компанийн Гүйцэтгэх захирал Гэрээ байгуулах шийдвэр, зөвлөмж хүлээн авснаас хойш хойш ажлын 5-аас доошгүй хоногийн дараа багтааж энэхүү журмын 2 дугаар хавсралтад тусгасан загварын дагуу “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ”-г байгуулна.

2.10. Аудитын компанийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 10 хувийг гэрээний хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг баримт бичигт тусгаж болно.

2.11. Шалгарсан оролцогчтой санхүүгийн, эсхүл гэрээний бусад нөхцөлөөр харилцан тохиролцоонд хүрээгүй бол Аудитын хороо дараагийн өндөр оноо авсан оролцогчийг сонгоно.

2.12. Аудитын хороо нь үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг хурлын тэмдэглэл хэлбэрээр гаргах ба хорооны гишүүдийн олонх дэмжиж гаргасан шийдвэр, түүний үндэслэл, холбогдох мэдээллийг агуулсан байна.

2.13. Үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид хорооны бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байгаа гишүүн үнэлгээний дүгнэлтэд энэ тухай тэмдэглэж гарын үсэг зурна.

Гурав. Ажлын чанарыг хянах

3.1. Аудитын компани аудитын ажлыг дуусгавар болгосноор дараах баримт, материалуудыг Аудитын хороо болон Гүйцэтгэх захиралд нэгэн зэрэг хүлээлгэн өгнө.

- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж
- Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг хянасан байдал
- Захиалагчид шаардлагатай судалгаа, мэдээлэл

3.2. Хөндлөнгийн аудитын гүйцэтгэсэн ажлын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг Аудитын хороо, Гүйцэтгэх захирал, Хөндлөнгийн аудитын байгууллагын төлөөлөл хамтран хэлэлцэж дүгнэлт гаргаж ТҮЗ-д танилцуулна.

3.3. ТҮЗ-өөс санхүүгийн нэгдсэн тайланг хэлэлцэх явцад болон дараа нь гүйцэтгэгчийн хийсэн аудиттай холбоотой эрсдэлтэй асуудал гарсан бол түүнийг гүйцэтгэгчид даруй мэдэгдэж, шаардлагатай засварыг хийлгэх, нотолгоо баримтыг шаардаж авна.

3.4. Хөндлөнгийн аудитын байгууллагын гүйцэтгэсэн ажлын чанарт Аудитын хороо дүгнэлт гаргаж үргэлжлүүлэн дараагийн ээлжит аудит хийлгэх эсэх талаар шийдвэр гаргана.

3.5. Аудитын компанийн үйлчилгээний гэрээнд тусгасан нөхцөлд төлбөрийн 10 хувийг ТҮЗ-ийн хурлаар нэгтгэсэн тайланг хэлэлцэж дууссаны дараа тухайн аудитын талаар эрсдэлтэй асуудал гараагүй тохиолдолд гүйцэтгэгчид төлнө.

Дөрөв. Журам хүчин төгөлдөр болох

5.1. Энэхүү журам нь “Улаанбаатар БҮК”ХК-ийн ТҮЗ-өөс баталсан шийдвэрт заасан хугацаанаас эхлэн хүчин төгөлдөр үйлчилийн.

АУДИТЫН ХОРОО